

УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ ХХК

“УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт шинжилгээ хийхэд:

Хэрэгжүүлэх арга хэмжээний үнэлгээ/гүйцэтгэл		Нийт
Хяналтад арга хэмжээний тоо		32
1	Бүрэн хангалттай 85%-иас дээш гүйцэтгэлтэй	32
2	Хангалттай буюу 70-85%-ийн гүйцэтгэлтэй	-
3	Хангалтгүй буюу 70 %-иас доош гүйцэтгэлтэй	-
Хэрэгжилтийн дундаж хувь		95%

Тус бодлогын баримт бичгийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-д заасан аргачлалын дагуу хийхэд хяналтад авсан 32 заалт Бүрэн хангалттай буюу 95%-тай хэрэгжсэн байна.

Хэрэгжилтийг холбогдох журмын дагуу үр дүнг тооцвол:

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин-Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин-Суурь түвшин}} * 100\% = \frac{95\%-0}{100\%-0} * 100\% = 95\% \text{ болно.}$$

Манай байгууллага нь 2025 онд шинээр байгуулагдсан тул суурь түвшинг 0-ээр тооцов.

Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт нь 5 зорилт 32 арга хэмжээний хүрээнд:

- 100%-тай хэрэгжсэн 15 арга хэмжээ
- 95%-тай хэрэгжсэн 2 арга хэмжээ
- 90%-тай хэрэгжсэн 15 арга хэмжээ тус тус байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж 95%-тай байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны биелэлтэд хийсэн үнэлгээний үр дүнг дараах зөвлөмж байдлаар хэлтэс албадад хүргүүлэв.

ЗӨВЛӨМЖ

1. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэж, байгууллагад хэрэгжсэн арга хэмжээний хүрсэн үр дүн, зарцуулсан төсөв хөрөнгө, хэрэгжилтэд нөлөөлж байгаа хүчин зүйл, хэрэгжилт хангалтгүй шалтгааныг бүрэн тусган тайлагнаж хэвшихийг бүх албан хаагчдад,

2. "Эрчимжүүлэх шаардлагатай" арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах хүрээнд удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж ажиллах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг хэлтэс, албадын удирдлагад,

3. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолж, эрсдэлийг бууруулж ажиллахыг нэгж, албадын удирдлагад,

4. Байгууллагын гүйцэтгэлийн биелэлт болон бусад тайлангийн хэрэгжилтийг тайлагнахдаа өмнөх тайланд тусгасан зөвлөмжийг хангаж, ХШҮ-ний нэгдсэн дүнгээр хангалтгүй хэрэгжсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг байгууллага, бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусгаж, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг бүх албан хаагчдад, тайлан, биелэлтэд хяналт тавьж гарын үсгээр албажуулан тайлагнаж ажиллахыг хэлтэс албадын дарга нарт тус тус зөвлөмж болгож байна.

ТАНИЛЦСАН:

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА  Ж.БАЛЖИННЯМ

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ЗАХИРГААНЫ АХЛАХ, ДОТООД ХЯНАЛТ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Т.ЭНХМАА

